



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот

**Тусгай зөвшөөрөл олгох тухай**

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 4 /дөрөв/ хуулийн этгээдэд “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай тус тус олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан хуулийн этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн  
197 тоот тогтоолын  
хавсралт



Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн  
жагсаалт

| № | Хуулийн этгээдийн нэр  | Хамрах хүрээ,<br>Үйлчилгээний хүртээмж                                                                  | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|---------------|----------------|
| 1 | Сонгодог технологи ХХК | Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх | 2025.09.18    | 2030.09.18     |
| 2 | НЭОМ ресурс ХХК        | Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх | 2025.09.18    | 2030.09.18     |
| 3 | Этернал хаая ранк ХХК  | Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх | 2025.09.18    | 2030.09.18     |
| 4 | Даймонд галба ХХК      | Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх | 2025.09.18    | 2030.09.18     |

----- оОо -----